



Техникийн өгөгдлийн хуудас

## Product 454™

Дэлхий дахины хувилбар, 1996 оны 2 сар

### БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАЙЛБАР

LOCTITE<sup>®</sup> Product 454 бол хурдан бэхжиж хатуурдаг, нэг бүрэлдэхүүн хэсэгтэй цианид акрил наалдуулах бодис бөгөөд үүнийг нааж барьцалдуулахад хэцүү эд ангиудад тусгайлан зориулж бүтээсэн байна. Энэ бүтээгдэхүүний найрлагад орсон гель уг цавууг босоо гадаргууд жигд тархаан урсгадаг байна.

### НИЙТЛЭГ ХЭРЭГЛЭЭ

Олон төрлийн метал, пластик юмуу уян харимхай зүйлс, тухайлбал мод, цаас, арьс ба даавуу мэт нүх сүвэрхэг буюу шингээгч материалуудыг түргэн барьцалдуулж наахад хэрэглэнэ.

### БЭХЖЭЭГҮЙ МАТЕРИАЛЫН НИЙТЛЭГ ШИНЖ ЧАНАР

	Хэмжээ	Нийтлэг	Хүрээ
Химийн бодисын төрөл		Этил циано крилат	
Харагдах байдал		Тунгалаг, нэвт гэрэлтдэг	
Хувийн гравитац - Specific Gravity @ 25 °C		1.1	
Наалдамхай чанар - 25 °C, Viscosity @ 25°C, mPa.s (cP)		Gel	
Асах цэг - Flash Point (TCC), °C		>80	

### БЭХЖИХ НИЙТЛЭГ ТӨЛӨВ

Ердийн нөхцөлд материалын гадарга дээрх агаарын чийгэнд бэхжиж эхэлдэг. Бэхжих үйл явц харьцангуй хурдан байх боловч химийн бодис болон уусгагч бодист тэсвэртэй болтлоо наад зах нь 24 хатаж бэхжих шаардлагатай.

### Бэхжих хурд ба материалын хамаарал

Бэхжих хурд нь хэрэглэж байгаа материалаас хамаарна. Доорх хүснэгтэнд 22 °C хэм 50% харьцангуй чийгтэй орчинд янз бүрийн материалын бэхжих хугацааг харуулжээ. Үүнийг ховхрох хүч нь 0.1 N/mm<sup>2</sup> болж бэхжих нэгж хугацаагаар тодорхойлж ASTM D1002 стандартын дагуу тодорхойлжээ.

Материал	Бэхжих хугацаа, секунд
Тосгүй болгож цэвэрлэсэн ган - Steel (degreased)	5 - 20
Хөнгөн цагаан - Aluminum	2 - 10
Цайр дихромт - Zinc dichromate	10 - 20
Неоприн - Neoprene	<5
Нитрил резин - Nitrile rubber	<5
Нитрилтэй резин - Rubber, nitrile	<5

Henkel Americas +860.571.5100

Henkel Europe +49.89.320800.1800

Henkel Asia Pacific +86.21.2891.8859

For the most direct access to local sales and technical support visit: [www.henkel.com/industrial](http://www.henkel.com/industrial)


Хоргүй пластик - ABS	2 - 10
Поли-хлор-винил пластик - PVC	2 - 10
Поли-карбонат - Polycarbonate	10 - 20
Фенолик - Phenolic	2 - 10

### Бэхжих хурд ба эд ангиудын нийлэх гадаргуугийн завсар зайн хамаарал

Бэхжих хурд нь мөн нийлүүлэн угсарч байгаа эд ангиудын хоорондох зай завсрын хэмжээнээс хамаарна. Наалдуулах материалын зузаан бага бол маш хурдан бэхжих ба хоёр биетийн хоорондын зай ихдэх тусам бэхжих хугацааг уртасгана.

### Бэхжих хурд ба чийгийн хамаарал

Бэхжих хурд нь орчны харьцангуй чийгнээс хамаарна. Дараах графикаар Нитрил резин жийрэг Vuna-N – ховхрох хүч чийгнээс яаж хамаарах хамаарлыг харуулжээ.



### Бэхжих хурд ба идэвхжүүлэгчийн хамаарал

Эд ангиудын хоорондын зай их том байх юмуу харьцангуй чийг багатай нөхцөлөөс шалтгаалан бэхжих хурд нь хэт удаан байвал бэхжих үйл явцыг хурдасгахын тулд идэвхжүүлэгч хэрэглэнэ. Гэвч энэ нь наадуулах хүчийг нь бууруулж болох тул аль хир чанартай барьцалдуулж байгааг нь шалгах хэрэгтэй.

## БЭХЖҮҮЛСЭН МАТЕРИАЛЫН НИЙТЛЭГ ТӨЛӨВ

### Физик шинж чанар

Дулаанд тэлэх коэффициент - Coefficient of thermal expansion, ASTM D696, K <sup>-1</sup>	80 x 10 <sup>-6</sup>
Дулаан дамжуулалтын коэффициент - Coefficient of thermal conductivity, ASTM C177, W.m <sup>-1</sup> K <sup>-1</sup>	0.1
Зөөлрөх температур - Glass transition temperature, ASTM, E228, °C	120

### Цахилгаан шинж чанар

Диэлектрик тогтмол ба алдагдал, 25°C, ASTM D150 стандартаар:	Тогтмол	Алдагдал
100Hz	2.65	<0.02
1kHz	2.75	<0.02
10kHz	2.65	<0.02

Эсэргүүцлийн эзлэхүүн - Volume resistivity, ASTM D257,	Ω.cm	1 x 10 <sup>16</sup>
Гадаргуугийнэсэргүүцэл - Surface resistivity, ASTM D257,	Ω	1 x 10 <sup>16</sup>
Диелекрик хүч - Dielectric strength, ASTM D149,	kV/mm	25

### БЭХЖҮҮЛСЭН МАТЕРИАЛЫН ТӨЛӨВ

22<sup>0</sup> C хэмд 24 цаг бэхжүүсний дараа:

		Нийтлэг	
		Хэмжээ	Хүрээ
Элсэн цэвэрлэгээтэй ганг шилжүүлж гулсуулах хүч - Shear Strength, ASTM D1002/DIN 53283			
Grit Blasted Steel,	N/mm <sup>2</sup> (psi)	22 (3200)	18 to 26 (2600 to 3800)
Барзайлгасан хөнгөн цагаан - Aluminum (etched)	N/mm <sup>2</sup> (psi)	15 (2200)	11 to 19 (1600 to 2800)
Цайр дихромтой - Zinc dichromate	N/mm <sup>2</sup> (psi)	7 (1000)	4 to 10 (600 to 1450)
Хоргүй пластик - ABS	N/mm <sup>2</sup> (psi)	13 (1900)	6 to 20 (900 to 3000)
Поли-хлор-винил пластик - PVC	N/mm <sup>2</sup> (psi)	13 (1900)	6 to 20 (900 to 3000)
Поли-карбонат -Polycarbonate	N/mm <sup>2</sup> (psi)	12.5 (1800)	5 to 20 (700 to 3000)
Фенолик - Phenolic	N/mm <sup>2</sup> (psi)	10 (1450)	5 to 15 (700 to 2200)
Неопренрезин - Neoprene rubber	N/mm <sup>2</sup> (psi)	10 (1450)	5 to 15 (700 to 2200)
Нитрил Резин - Nitrile rubber	N/mm <sup>2</sup> (psi)	10 (1450)	5 to 15 (700 to 2200)
Сунаж тасрах хүч - Tensile Strength, ASTM D2095, DIN 53282			
Элсэн цэвэрлэгээ хийсэн гангаас - Grit Blasted Steel,	N/mm <sup>2</sup> (psi)	18.5 (2700)	12 to 25 (1700 to 3600)
Нитрил Резин - Buna N rubber,	N/mm <sup>2</sup> (psi)	10 (1450)	5 to 15 (700 to 2200)


## ОРЧИН ТОЙРНЫ НӨХЦӨЛД ТЭСВЭРТЭЙ БАЙДАЛ

Сорилын журам: Гулсуулж ховхлох хүч - Shear Strength ASTM D1002/DIN 53283

Материал: Элсэн цэвэрлэгээ хийсэн ган


Бэхжүүлэх горим: Долоо хоногийн турш 22<sup>0</sup> С хэмд бэхжүүлэх

### Халуун тэсвэрлэх чадвар



### Халуунд ховхорч салах дулааны хэм - Heat Aging

Халуунд ховхорч салах чадварыг нь 22 °С хэмээс эхлэн халуунд хэр удаан тэсэх хугацааны хамаарлаар түршиж харуулжээ.



### Химийн бодис/Уусгагч бодист тэсвэртэй байдал

Химийн бодист хэр тэсвэртэй болохыг туршилтаар 22<sup>0</sup>С хэмд тодорхойлжээ.

Уусгагч бодис	Хэм	Үндсэн чадварын хувь, %		
Орчин	°C	100 цаг	500 цаг	1000 цаг
Моторын тос	40	85	85	75
Бензин хар тугалагатай	22	100	100	100

Этанол	22	100	100	100
Изопропанол	22	100	100	100
Фреон Т. А	22	100	100	100
95% RH – харьцангуй чийг	40	65	55	50
98% RH – харьцангуй чийг	40	100	100	100

## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

**Энэ бүтээгдэхүүнийг дан хүчилтөрөгч/хүчилтөрөгч ихтэй системд хэрэглэхэд зохимжгүй бөгөөд хлортой юмуу хүчтэй исэлдүүлэгч материалуудыг хааж тусгаарлах зорилгоор ашиглаж болохгүй. Эдгээр бүтээгдэхүүнийг ашиглахдаа баримтлах мэдээллийг Аюулгүй ажиллагааны дагалдах хуудаснаас үзнэ үү.**

### Хэрэглэх заавар:

Наалт хийх орчин цэвэр, тосгүй байх ёстой. Энэ бодис 0.05мм-ээс бага зайд маш сайн үйлчилнэ. Цавууны үлдэгдлийг LOCTITE®-ын уусмал, нитрометан юмуу ацетаноор уусгаж цэвэрлэх боломжтой.

### Хадгалалт

Эдгээр бүтээгдэхүүний шошгон дээр өөрөөр заагаагүй бол хуурай сэрүүн газар битүүмжилсэн контайнерт 8°C - 21°C хэмд хадгална. Онгойлгоогүй савтай циано крилате бодисыг хадгалах нөхцөлийг цельсийн 2-8 хэмд хүртэл хөргөх замаар бүрдүүлж болно. Хөргөж хадгалсан бүтээгдэхүүнийг ашиглахын өмнө гаргаж тасалгааны хэмд оруулах хэрэгтэй. Ашиглаагүй бүтээгдэхүүнийг бохирдохоос сэргийлэх зорилгоор нэгэнт гаргаж хэрэглэсэн бодисыг саванд нь буцааж хийхийг хориглоно. Тусгайлсан тавиур дээр хадгалах хугацааны талаар Техникийн үйлчилгээний төвд хандах хэрэгтэй.

### Мэдээллийн хугацаа

Энд тусгасан хугацааны хязгааруудыг нийтлэг хэмжээгээр (дундаж хэмжээнээс нь +- 2 стандарт хэлбэлзэлтэй) авсан байж болно. Тухайн бүтээгдэхүүний эдгээр өгөгдлүүдийг тодорхой хугацаанд шалгаж бодит үр дүнг тайлагнадаг.

### Тэмдэглэл:

Уг бүтээгдэхүүнийг өгөгдлүүдийг зөвхөн мэдээлэх зорилгоор энд өгсөн боловч итгэлтэй мэдээлэл болно. Манай бүтээгдэхүүнийг та бүхэн бидний хяналтгүйгээр өөрсдийн тусгай зорилго, ажлын нөхцөлд ашиглаж болох юм. Тийм учраас Henkel-ийн бүтээгдэхүүн та бүхний үйлдвэрлэлийн процесс ба орчны нөхцөлд тохирч байгаа эсэх, тэднийг зориулалтаар нь хэрэглэж хүссэн үр дүнд хүрсэн эсэх талаар компани хариуцлага хүлээхгүй. Манай бүтээгдэхүүн танай хэрэгцээнд тохирох эсэхийг өөрсдөө урьдчилсан туршилтаар тогтоож байхыг зөвлөж байна. Техникийн Өгөгдлийн хуудас (TDS) –т орсон мэдээлэл, энэ бүтээгдэхүүнд хамаарах бичгээр болон амаар өгсөн зөвлөмжүүдийн төлөө компани хариуцлага хүлээхгүй. Уг бүтээгдэхүүнтэй холбоотой хуулийн зүйл ангийг манай тал мөрдөөгүй юмуу хэрэгсээгүйгээс үүдэлтэй хүний бэртэл, үхэлтэй холбоотой асуудлын талаар зориуд нарийвчлан тодорхойлж зөвшилцөөгүй бол хариуцлага хүлээхгүй.

Энд яригдаж байгаа янз бүрийн процессууд юмуу бүрэлдэхүүн хэсгүүдийг патент эзэмшигчид болон Henkel Corporation-ийн янз бүрийн процессууд юмуу бүрэлдэхүүн хэсгүүдийн патентад хамаарах лицензээс давуу эрхтэй гэж ойлгож болохгүй. Энэ бүтээгдэхүүн АНУ-ын юмуу бусад оронд бүртгэгдсэн нэг буюу хэд хэдэн патенттай байж болно.